



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 54,500,000.00 (тавин дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 38,275,619.51 (гучин найман сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун арван есөн төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу 8,150,000.00 (найман сая нэг зуун тавин мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3.Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбат, Орхон аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Өлзийсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000033



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн
 өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт

Орхон аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
 нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах автомашин

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 390 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Х-трайл, 00-39 ОРО, арал №JN1MANT31ZO1 02761	2012/ 2012	54,500,000.00	38,275,619.51	16,224,380.49	16,300,000.00	8,150,000.00	2,037,500.00
	Нийт дүн		54,500,000.00 (тавин дөрвөн сая таван зуун мянган)	38,275,619.51 (гучин найман сая хоёр зуун далан таван мянга зургаан зуун арван есөн төгрөг тавин нэгэн мөнгө)	16,224,380.49 (арван зургаан сая хоёр зуун хорин дөрвөн мянга гурван зуун наян төгрөг дөчин есөн мөнгө)	16,300,000.00 (арван зургаан сая гурван зуун мянга)	8,150,000.00 (найман сая нэг зуун тавин мянга)	2,037,500.00 (хоёр сая гучин долоон сая таван зуун)